

УЛС ТӨРИЙН НАМЫН ҮЗЭЛ СУРТАЛ БА ТҮҮНИЙ ҮНДСЭН ХЭЛБЭРҮҮД

Ц.ГАНБОЛД

Профессор, МУИС. Улс төр судлалын тэнхим

Т.БИЛЭГСЭЙХАН

Улс төр судлалын тэнхимийн магистрант

Түлхүүрүг: үзэл суртал, улс төрийн нам, идеологи, либерализм, социализм, энвиронментализм, консерватизм,

Хураангуй: Улс төрийн намын үзэл суртал болон түүний хэлбэрүүдийг задлан шинжилж өнөөгийн Монголын улс төрийн намуудын үзэл сурталтай харьцуулсан судалгаа юм. Мөн үзэл суртал болон улс төрийн намын үүсэл гарлыг тодруулж улс төрийн намын үзэл суртал бүрэлдэх үндэслэгээг гаргасан.

Үзэл суртал: Англи хэлний *ideology* буюу үзэл суртал нь 18-р зууны сүүл үеэс Шинжлэх ухаанд хэрэглэгдэх болсон бөгөөд 19-р зууны эхний хагсаас эхлэн нийгэм, улс төрийн салшгүй чухал ухагдахуун болсон. Хэл зүйн талаасаа үзэл суртал /идеологи/ нь эртний Грекийн *idea* буюу санаа, ойлголт, сэтгэмж, *logos* буюу тухайн цаг үеийн илтгэх, үг хэлэх, ярилцах гэсэн үгийн нийлэмж бөгөөд 18-р зууны эхэн үед франц хэлэнд *ideologie* анхлан хэрэглэгдэж эхэлсэн бөгөөд Францын философич Дестут Дэ Траси¹ “Шинжлэх ухааны санаанууд” гэдэг ойлголтоор оруулж ирсэн. “Ideology” нь хувь хүн, бүлэг, нийгмийн итгэл үнэмшлийн цогц бөгөөд анхлан хувь хүний үзэл бодлын шинжлэх ухааны ойлголт хэлбэрээр хэрэглэгдэж байсан.

Дэлхийн хоёрдугаар дайны үеэс Германы Нацизм, Италийн Фашизм нь “Ideology”-г шинэ хэлбэртэй болгосон бөгөөд энэ нь аливаа нэг улсын өөрт онцгой гэж хүлээн зөвшөөрсөн үнэт зүйлс, зорилго болон тэрхүү зорилгодоо хүрэхийн тулд бий болгосон институт, бүтцийг илэрхийлэх болжээ. Үзэл суртал нь жижиг бүлгийн болон нийт массыг хамарч болох өргөн хүрээний ойлголт юм. Нэг улс болон олон улсууд дундын үзэл сурталтай байж болох ба зарим тохиолдолд бүр дэлхийн хэмжээний ч байж болдог. Үзэл суртал нь 20-р зуунаас түгээмэл хэрэглэгддэг ухагдахуун болсон бөгөөд дундад зууныг “Итгэл бишрэлийн зуун”, 18-р зууныг “Сэргэн мандалтын зуун” гэсэн бол 20-р зууныг “Үзэл сурталын зуун” хэмээн нэрлэх нь бий.

Үзэл суртал нь нийгмийн шинжлэх ухаанд тогтсон нэг ойлголтгүй бөгөөд олон төрлийн салаа утгуудыг агуулж байдаг. Үүнд:

1. Үзэл суртал бол улс төр, нийгмийн сургаалыг бий болгох зорилготой төрийн, намын, бүлгийн зан үйлүүдэд чиглэл гаргах, төр, хууль, шинжлэх ухаан, философи, шашин, ёс зүйн хэм хэмжээний цогц,
2. Нийгмийн амьдрал дахь ойлголт, илэрц, үнэт зүйл бий болох хугацаа,
3. Тодорхой нэг нийгмийн бүлэг эсвэл ангийн үзэл санааны нийтлэг,
4. Нэг улс төрийн хүчийг бүрэн эрхт хууль ёсны болгоход чиглэгдсэн буруу ойлголт,
5. Улс төрийн болон нийгмийн нэг сургаал бий болгох эсвэл нэг засгийн газрын, намын, нийгмийн бүлгийн үйл ажиллагаанд чиглэл өгөх үзэл санааны систем юм.

Үзэл суртал ялгаатай ойлголтуудтай байгаа нь зарим сөрөг нөлөөг бий болгодог. Нийгмийн амьдралд оролцож буй хүмүүсийн өөр хоорондоо хэлэлцэж, мэтгэлцэж буй асуудлууд эерэг болон сөрөг олон талт байдалтай байх бөгөөд үүнээс урган гарах санаа бодлууд бүхэлдээ үзэл суртал юм шиг ойлголтыг бий болгох сөрөг талтай байдаг.

Бүх санаа бодлууд үзэл суртал болж чадахгүй учир үзэл суртал болохын тулд үндсэн хоёр шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд санаа бодлууд нь үр нөлөөтэй бөгөөд бодитоор орших боломжтой байх, мөн санаа бодлуудын үндэслэгээ нь улс төрийн шалтгаантай байх шаардлагатай.

Улс төрийн нам: Үзэл бодлоороо эвлэлдэн нэгдсэн, сонгуулийн замаар засгийн эрхийг авах эцсийн зорилготой бүлэг хүмүүсийн нэгдэл, улс төрийн байгууллага юм. Нийгмийн олон ургалч үзэл хандлага, олон талт байдлын төлөөлөл төдийгүй түүнийг нэгдмэл бодлого дор зангидан, иргэдийн улс төрийн оролцоог хангах институт болдог. Нам гэдэг нэр томъёо нь *pars* буюу хэсэг бүлэг гэсэн латин үгнээс гаралтай бөгөөд намын тухай үзэл санаа нь Эртний Грек, Ромын үеэс эхлэлтэй. М.Вебер² улс төрийн намын үүсэл, хөгжлийг

¹ Destutt de Tracy /1754-1836/

² Max Weber /1864-1920/

ангилахдаа “язгууртны бүлэглэл, улс төрийн клуб, олон түмний нам” гэсэн үндсэн гурван үе шатыг дамжсан гэж авч үзсэн.

Анхны улс төрийн бүлэглэл 17-р зуунд Англид үүссэн бөгөөд Протестант Үндсэн хуульт хаант засгийн талийг баримтлагч Вигс/Whigs/ болон Абсолют хаант засгийн талыг баримтлагч Язгууртнуудын бүлэглэл болох Тори /Tories/-чуудын төрийн эрхийн төлөөх тэмцлээс эхлэсэн гэж үздэг. Сонгодог утгаараа улс төрийн нам 18-р зууны төгсгөл үед АНУ-д Холбооны засгийн газрыг байгуулах зорилгоор, сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн хүмүүс Холбооны болон Бүгд Найрамдах намуудыг байгуулснаар бий болсон гэж үздэг.

Улс төрийн нам хэлбэрийн хувьд олон намын систем, хоёр намын систем, нэг намын систем болон намгүй гэж ангилагддаг. Олон намын систем гэдэг нь парламентын сонгуулиар засгийн эрхэнд хоёроос олон нам сонгогдож, төлөөллийн байгууллага байгуулдаг. Хоёр намын систем нь давамгайлалт хоёр нам парламентын сонгуульд ялалт байгуулж төлөөллийн байгууллагыг бүрдүүлэх бөгөөд бусад жижиг нам эвслүүд ялалт байгуулах бараг боломжгүй тогтолцоо юм. Нэг намын систем нь үндсэн хууль болон бусад хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн улс төрийн ганцхан хүчин төрийн эрхийг барих бөгөөд засгийн бүх эрхийг нэг цэгт төвлөрүүлэн удирддаг. Намгүй тогтолцоонд ямар нэгэн албан ёсны улс төрийн хүчинг баталгаажуулдаггүй бөгөөд сонгогдогч нь ямар нэгэн бүлгийг төлөөлж хариуцлага хүлээхгүйгээр гагцхүү өөрийн хүчин чармайлтаараа төлөөллийн байгууллагад сонгогдон ажилладаг.

Улс төрийн намын бусад нийгмийн институтээс ялгарах онцлог нь засгийн эрхийг бүрэн авах, түүнд оролцох, томоохон сонирхлын бүлгүүдийн эрх ашгийг нэгтгэж түүнийгээ илэрхийлсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, улс орны болон бүс нутгийн нэгж бүрт өөрсдийн намын хороог зохион байгуулж, төвөөс удирдсан босоо бүтэцтэй, иргэд сонгогчдын дэмжлэгийг олох зорилготой, нэгэн үзэл суртлыг үнэт зүйлээ болгосон, сайн дурын үндсэн дээр нэгдсэн гишүүд дэмжигчдийг бэлдэх зэрэг юм.

Улс төрийн нам нь үндсэн дөрвөн үүрэг хүлээдэг. Үүнд:

1. Ард түмний эрх ашигт нийцүүлэн ажиллах үүрэг: Улс төрийн нам нь тухайн улсынхаа ард иргэдийн нэг хэсэг, хүсэл зорилгынх нь төлөөлөл болж сонгуульд оролцох бөгөөд ялалт байгуулж засгийн эрхэнд гарсан тохиолдолд ард түмний эрх ашгийг нэн тэргүүнд тавин ажиллах.
2. Улс төрийн үүрэг: Сонгуулиар ялалт байгуулж олонхи болсон улс төрийн нам төрийн бодлогыг тодорхойлж, төрийн албан тушаалд өөрсдийн хүмүүсийг бэлтгэн байршуулах бөгөөд төрийн үйл ажиллагааг өөрсдийн эрх мэдлийн дагуу удирдан зохион байгуулах.
3. Нийгмийн үүрэг: Иргэдийн ашиг сонирхлыг нэгтгэн тодорхойлохыг эрмэлздэг бөгөөд тэдний хүсэл зоригоо илэрхийлэх арга замыг “зааж” өгөн, шаардлагыг нь зохих тодорхой түвшинд гаргах (хурал, жагсаал, цуглаан зохион байгуулахаас эхлээд хувьсгалд уриалан дууддаг).
4. Үзэл суртлын үүрэг: Нийт нийгмийн гишүүд болон өөрийн гишүүдээ улс төрийн тодорхой үзэл баримтлалыг санал болгож түүндээ тулгуурлан итгэл үнэмшил бий болгосноор гишүүд дэмжигчид, иргэдийн дунд өөрсдийн орон зай, байр сууриа бий болгодог.

Улс төрийн намын үзэл суртал нь тухайн улсын түүх, иргэдийн онцлог, зан төлөв, нийгмийн анги, бүлэг, үнэт зүйлс, зохион байгуулалт, дотоод болон гадаад нөхцөл байдлаас шалтгаалж олон төрөл байдаг. Эдгээрээс хамгийн түгээмэл идеологи нь либерализм, консерватизм, социализм болон сүүлийн жилүүдэд хүчтэй хөгжиж байгаа энвайронментализм юм.

Либерализм: Нийгмийн амьдралын бүх салбарт хувь хүний эрх чөлөөг хэрэгжүүлэх нь нийгмийн хөгжлийн нөхцөл мөн гэсэн үзлийг тунхагладаг хөдөлгөөн, нийгэм улс төрийн чиг баримжаа юм. Либерализм нь эдийн засгийн салбарт хувь хүний өмч, эрх чөлөө, тэдний чөлөөт өрсөлдөөнийг, улс төрийн хүрээнд эрх зүйт төр, хуулийн засаглал, парламентын ардчилал, иргэдийн улс төрийн эрх, эрх чөлөөг хангах үйл явцыг дэмждэг.

Англи, Америк, Францын хувьсгалуудын үзэл суртал нь либерализм болж байсан бөгөөд хэмжээгүй эрхт хаант засгийг унагаж, дарлагдсан тариачид, боолуудын эрх чөлөөг олж авах тулгуур зарчимтай байв. Либерализмын гол сэтгэгчид нь Ж.Локк³, Ж.С.Милл⁴ бөгөөд орчин үеийн либерал үзэл баримтлалтай сэтгэгчдээр Ж.Роулс⁵, К.Поппер⁶ тэргүүтэй судлаачдыг нэрлэж болно.

Либерализмын суурь ойлголтууд:

- Хувь хүн /Individualism/: Ямар нэгэн бүлэг хамтралын эсрэг хувь хүний байр суурийг хамгийн дээгүүрт тавьж үзэх,

³ John Locke /1632-1704/

⁴ John Stuart Mill /1806-73/

⁵ John Rawls /1921 - 2002/

⁶ Karl Popper /1902- 1994/

- Эрх чөлөө /Freedom/: Үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, чөлөөт худалдаа, иргэний эрх, ардчилсан нийгэм, хүйсний тэгш байдал, олон улсын хамтын ажиллагаа, шашнаас ангид төр,
- Тэгш байдал /Equality/: Хувь хүн бүр байгалиасаа адил тэнцүү төрдөг, хуулийн болон шүүхийн өмнө бүгд ижил тэнцүү байх,
- Хүлээн зөвшөөрөх /Consent/: Төр болон нийгмийн харилцаа нь хүлээн зөвшөөрөгдсөн гэрээнд суурилсан байх,
- Учир шалтгаан /Reason/: Либерал үзлээр дэлхий ертөнц рационал бүтэцтэй бөгөөд хувь хүн өөрийн хэрэгцээ, сонирхол, үйл хэрэгтээ бүрэн хариуцлага хүлээх чадамжтай гэж үздэг,
- Тэвчээр /Toleration/: Либерал үзлээр тэвчээр (бусдын санаа бодлыг хүлээцтэй сонсох) нь хувь хүн эрх чөлөө болон нийгмийн амьдралыг баяжуулах баталгаа болж өгдөг гэж үздэг.
- Үндсэн хуульт ёс /Constitutionalism/: Хувь хүний эсрэг дарангуйллын төр байхаас сэргийлж нийгмийн гэрээний бичиг буюу үндсэн хуулиар төрийн эрхийг хязгаарлах

Либерал үзэл сурталтай улс төрийн нам нь ардчилсан институт болон иргэний нийгмийг дэмжсэн, эрх зүйт төрийг дээдэлсэн, зүүн төвт үзэл баримтлалтай, хувь хүн бүр өөрийн эд хөрөнгө, угсаа гарвал, арьсны өнгө, шашин шүтлэгээсээ үл хамаарч хууль, шүүхийн өмнө тэгш бөгөөд хамгаалагдсан эрхтэй байх тулгуур зарчмыг баримталдаг.

Либерал үзэл баримтлалтай улс төрийн намын

- *Эдийн засгийн бодлого*: Хувь хүний өмчийн эрх болон эрх чөлөө нь либерал үзэл баримтлалын үндсэн суурь нь болох бөгөөд чөлөөт зах зээлийн тэнцвэрийг хадгалах үүднээс засгийн газрын ямар ч оролцоо эдийн засагт байх ёсгүй гэж авч үздэг.
- *Татварын бодлого*: Төрийн үйл ажиллагааг хангах хэмжээнд л татвар хамгийн бага бөгөөд хязгаарлагдмал байх ёстой.
- *Худалдааны бодлого*: Чөлөөт худалдаа бол эдийн засгийн хамгийн зөв сонголт бөгөөд энэхүү системээс бүх хүн ашиг хүртэж чадна гэх бодлогод үндэслэдэг.
- *Арьс өнгөөр ялгаварлах*: Хүнийг ялгаварлан гадуурхах нь хувь хүний эрхэнд аюул учруулж байдаг. Нийгэм бүх хүмүүст тэнцүү боломжийг олгоход суурилсан байх хэрэгтэй бөгөөд хэн нэгэн хүнийг арьс, хүйс, шашин болон соёлоор нь ялгаварлан гадуурхахын эсрэг зогсдог.
- *Хүрээлэн буй орчны бодлого*: Хүрээлэн буй орчныг хүний нөлөөллөөс үүдэлтэй сүйрэл гэмтлээс хамгаалах шаардлагатай бөгөөд аль хэдийн сүйдсэн бол түүний нөхөн сэргээх үйл ажиллагааг явуулж, хүрээлэн буй орчны хамгаалалт, нөхөн сэргээх үйл ажиллагаанд бизнесийн байгууллагуудтай хамтран ажиллах хууль эрх зүйн орчныг бий болгож ажилладаг.
- *Нийгмийн хамгааллын бодлого*: Ахмад настан, өвчтэй болон эмзэг бүлгийнхнийг хамгаалахад зориулж үйл ажиллагаа явуулдаг.
- *Цагаачлалын бодлого*: Цагаачлалын урсгалыг зохицуулах төрийн ямар нэгэн бодлого байхгүй бөгөөд хувь хүн өөрийн эрх чөлөөг бүрэн эдэлж, бүх улсуудад чөлөөтэй зорчих эрх нь нээлттэй гэж үздэг.
- *Гадаад бодлого*: Дайн гарахаас сэргийлж НҮБ болон бусад Олон улсын байгууллагуудыг дэмжих бодлого баримтлах хэдий ч хамтын аюулгүй байдлаа хамгаалах үйл ажиллагаанд үл итгэж, эвсэлд нэгдэхийн эсрэг байр суурь баримталдаг.
- *Нийгмийн бодлого*: Иргэний эрх чөлөө нь бүх иргэдэд ижил тэнцүү хүрэх хэрэгтэй. Эрүүл мэндийн хамгийн наад захын стандарт болон боловсролыг бүгдэд хүртээх зорилготой.
- *Хүний эрхийн талаарх бодлого*: Хүний эрх бол түгээмэл шинжтэй. Цаазаар авах ял нь хүнлэг бус үйлдэл бөгөөд үүнийг арилгахын төлөө ажилладаг.

Консерватизм: Уламжлалт үнэт зүйлс, дэг журмыг хадгалж хамгаалан, нийгмийн эрс өөрчлөлтийг эсэргүүцдэг улс төрийн хөдөлгөөн, үзэл суртлын чиг баримжаа бөгөөд төр улсын статус-квог зөвтгөж, оршин байгаа нийгмийн байгууламжийн үндсийг тогтворжуулж, бэхжүүлэх үндсэн зорилготой. Консерватив үзэл суртал нь 18-р зууны сүүл 19-р зууны эхэн үед Францын хувьсгалаар эхлэсэн эдийн засаг, улс төрийн хувьсгалт эрс өөрчлөлтийг эсэргүүцэж гарч ирсэн бөгөөд томоохон төлөөлөгчдөд нь Р.Хүкэр⁷ Э.Бюрк⁸ нарын олон философич, улс төрчид гэж тооцогддог.

⁷ Richard Hooker /1554-1600/

⁸ Edmund Burke /1729-97/

Суурь ойлголтууд нь:

- Уламжлал */Tradition/*: Консерватизмын үндсэн зорилго нь уламжлалаа хадгалж хамгаалахад оршдог, тогтсон ёс заншлаа хүндэтгэж, цаг хугацааны шалгуураар үлдсэн төрийн байгууламж хэв маягаа хэвээр хадгалах зорилготой.
- Прагматизм */Pragmatism/*: Хүний оюун ухаан хязгаарлагдмал юм. Хийсвэр зарчим болон сэтгэлгээний систем нь найдваргүй байдаг. Иймд туршлага болон түүхийн ололтуудад тулгуурлах үзлийг баримталдаг.
- Хүний төгс бус байдал */Human Imperfection/*: Хүн төрөлхтөн бүхэлдээ гутранги, ямар нэг зүйлээс хамааралтай, хязгаарлагдмал бөгөөд үргэлж хараа хяналт, хамгаалалтыг хүсч, шаардаж байдаг. Иймд тэднийг тогтвортой, дүрэм журамтай нийгэмд амьдруулах шаардлагатай.
- Органицизм */Organicism/*: Нийгмийг хүний мэргэн ухааны бүтээл гэж үзэхийн оронд консервативууд нийгэм бол бүхэлдээ органик бөгөөд амьд нэгж гэсэн уламжлалт үзлээр авч үздэг.
- Шатлан захирах ёс */Hierarchy/*: Консерватив үзлээр нийгмийн байдлын болон статусын дэс дараалал нь органик нийгэмд зайлшгүй бөгөөд төрөлхийн байдаг. Эдгээр нь төрийн албан хаагчдын, ажилчдын, багш-сурагчдын, гэр бүлийн болон хүүхдүүдийн өөр хоорондоо ялгагдах үүрэг хариуцлагуудыг тусган харуулдаг. Энэхүү ойлголтоор тэгш бус байдал болон шатлан захирах ёс нь бие биетэйгээ зөрчилдөхгүй юм.
- Эрх мэдэл */Authority/*: Эрх мэдэл нь удирдагчаас эхлэн дээрээс доошоо гэсэн босоо бүтэцтэй бөгөөд мэдлэггүй, боловсролгүй, туршлагагүй хүмүүст өөрийн хүсэл зоригийн дагуу зөв үйлдэл гаргахад нь тусламж дэмжлэг үзүүлэх ёстой гэж үздэг.
- Өмч */Property/*: Өмч эзэмшигчдээ төрөөс болон бусад зүйлсээс хараат бус байх боломжийг олгох маш чухал үүрэгтэй бөгөөд хууль болон бусдын өмч хөрөнгөд хүндэтгэлтэй хандах, өмчтэй харилцах эрх болон үүргийг үүсгэдэг гэж үздэг.

Консерватизм улс төрийн баруун чиг баримжаатай бөгөөд дээр өгүүлсэн Английн хэмжээгүй эрхт хаант засгийн талыг баримтлагч Торичуудаас эхлэн консерватив улс төрийн намын үзэл суртал бүрэлдсэн гэж үзэж болно (Institute, 2008). Сүүлийн жилүүдэд баруун төвт үзэл баримтлалтай улс төрийн намууд, Институтуудад ач холбогдол өгөх нь нэмэгдэж байгаа бөгөөд мөн нийгмийн олон талт болон эдийн засгийн тулгамдсан асуудлуудад ихээхэн анхаарал хандуулж байна. 1970-аад оны дундаас Баруун төвт үзэл баримтлалтай улс төрийн намууд засгийн газрын үр ашиггүй зардал болон төрийн хэмжээ хязгааргүй томролтыг эсэргүүцэж, эдийн засагт оролцох төрийн оролцоог бууруулах тал дээр үйл ажиллагаа явуулснаар эдийн засгийн өсөлт нэмэгдэж, улмаар үндэсний үзэл сэргэх бөгөөд нийгмийн анги хоорондын тэмцэл буурна гэж авч үзсэн.

Баруун төвт консерватив үзэл баримтлалтай улс төрийн намын

- *Эдийн засгийн бодлого*: Капитализм ба чөлөөт худалдааг дэмжинэ.
- *Татварын бодлого*: Бизнесийн үйл ажиллагааг дэмжсэн бодлого баримталж, laissez-faire буюу чөлөөт эдийн засгийн бодлогод тулгуурлан, жижиг цомхон төрийн үйл ажиллагаатайгаар эдийн засагдах төрийн оролцоог багасгаж гагцхүү мөнгөний нийлүүлэлтэд хяналт тавьж ажилладаг. Татвар нь хязгаартай бөгөөд цэрэг, цагдаагийн үйл ажиллагааны санхүүжилтэд зарцуулах бодлого баримталдаг.
- *Худалдааны бодлого*: Хөнгөлөлттэй үнэ тарифыг хасаж чөлөөт худалдааг дэмждэг.
- *Хүрээлэн буй орчны бодлого*: Чөлөөт худалдааг хамгаалах үүднээс бизнест нөлөөлөх байгаль орчны хязгаарлалтуудыг бууруулдаг.
- *Нийгмийн хамгааллын бодлого*: Нийгмийн хамгааллыг хувийн секторт шилжүүлэх нь үр дүнтэй гэж авч үздэг.
- *Цагаачлалын асуудал*: Үндэснийхээ бүрэн эрхт байдлыг нэн тэргүүнд тавих үүднээс цагаачдын асуудалд нухацтай ханддаг.
- *Гадаад бодлого*: Гадаад бодлогын үндэс нь “реализм”-д суурилсан бөгөөд өөрсдийн аюулгүй байдлаа нэн тэргүүнд тавьдаг.
- *Нийгмийн бодлого*: Ерөнхийдөө сүм хийд болон төрийн үйл ажиллагаа тусгаарлагдмал гэж итгэдэг хэдий ч хамгийн сайн нийгмийн бүтэц нь шашны итгэл бишрэлд суурилсан байх бөгөөд гэмт хэрэг, ядуурал зэрэг асуудлууд нь нийгмийн инженерчлэл явагдсанаар шийдэгдэх боломжтой гэж үздэг.

Социализм: Социализмын үзэл санаа Платоны үед⁹ болон 16-р зууны Т.Моррийн “Утопи” хэмээх зохиолуудад гарч байсан боловч 19-р зууны эхэн хүртэл улс төрийн үзэл суртлын хэлбэрээ ололгүй явсаар ирсэн. Социализм нь зах зээлийн арилжаа солилцоонд суурилсан капиталист эдийн засгийг устгаж оронд нь нийтийн өмчид суурилсан социалист нийгмээр өөрчлөх үндсэн зорилготой улс төр нийгмийн үзэл суртал

⁹ Платоны “Republic” номонд

юм. Хамгийн нөлөөтэй ээтгэгч нь К.Маркс бөгөөд түүний үзэл санаанд тулгуурлан 20-р зууны коммунизмын эхлэл тавигдсан.

Суурь ойлголтууд нь:

- **Нийгэмлэг /Community/:** Хувь хүний төрх байдал нь нийгмийн харилцан үйлчлэл болон нийгмийн бүлэг хамтралуудын нөлөөгөөр тогтдог. Энэ нь нийгэмлэгийн хувьд чухал нөлөөтэй бөгөөд социализмын үндэс нь болж өгдөг.
- **Ах дүүгийн барилдлага /Fraternity/:** Хүмүүс нийтлэг шинж чанартай бөгөөд нөхөрлөл ах дүүгийн нарийн холбоосоор өөр хоорондоо холбогдсон байдаг. Энэ нь хүмүүсийн хамтач байдал, хувь хүнийг биш коллективизмыг эрхэмлэх шалтгаан болдог гэж үздэг.
- **Нийгмийн тэгш байдал /Social equality/:** Социализмын утга учир нь тэгш байдал. Нийгмийн тэгш байдлын хэмжүүр нь нийгмийн тогтвортой байдал болон нягт холбоог сайжруулах хамгийн чухал хөшүүрэг гэж үздэг.
- **Хэрэгцээ /Need/:** Чадлынхаа хэрээр ажиллаж, хийснийхээ хэрээр олж авна гэдэг К.Марксын зарчимд тулгуурладаг.
- **Нийгмийн анги /Social class/:** Социалист нийгмийн үндэс суурь нь анги байдаг.
- **Нийтийн өмч /Common ownership/:** Хувийн өмч нь амиа бодох үзэл, нийгмийн хуваагдал болон өмч эзэмших хүслийг дэвэргэдэг гэж үздэг учраас өмч нь нийтийн эзэмшилд байх ёстой гэх зарчимд тулгуурладаг.

Социализмын үзэл санаанаас үндэслэн төр ба зах зээлийн, хувь хүн ба нийгмийн бүлэг хоорондын тэнцвэртэй харилцааг эрхэмлэсэн Социал-Демократ үзэл суртал үүсэн гарсан. Энэ нь нэг талаас зах зээлийн эдийн засагт баялгийг бүтээхийн тулд капитализмын зарчмыг хэрэгжүүлэх бөгөөд нөгөө талаас төрөөс авч хэрэгжүүлэх нийгмийн бодлого, халамжыг тууштай явуулах зүүн төвт үзэл баримтлал юм.

Социал-Демократ үзэл баримтлалтай улс төрийн намын

- **Эдийн засгийн бодлого:** Капиталист эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлж, нийгмийн эмзэг бүлгийг хамгаалсан халамжийн төрийн үйл ажиллагаа явуулдаг. Боловсрол, эрүүл мэнд, хүүхэд асрах болон дэд бүтцийн салбаруудыг дэмжих зорилгоор системтэй программуудыг боловсруулан хэрэгжүүлдэг.
- **Татварын бодлого:** Нэн шаардлагатай байгаа төрийн үйлчилгээг үзүүлэхийн тулд хувь хүний орлогын түвшингээс хамааран, дундаас дээш, өндөр хэмжээний өсөн нэмэгдэх татварын бодлого баримтладаг.
- **Худалдааны бодлого:** Дотоодын үйлдвэрлэл, хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалсан худалдааны бодлого хэрэгжүүлж, шударга өрсөлдөөнийг дэмжин, хориотой бус чөлөөт худалдааг сайшаадаг.
- **Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах:** Эдийн засаг, нийгмийн бүхий л хүрээнд төрийн зүгээс иргэддээ тэгш байдлыг дэмжсэн бодлого баримтлах бөгөөд арьс өнгөөр ялгаварлан гадуурхахын эсрэг үйл ажиллагаа явуулдаг.
- **Хүрээлэн буй орчны бодлого:** Хүрээлэн буй орчны бодлого нь төрийн үйл ажиллагаанд хуулиар зохицуулагдсан байх бөгөөд байгаль орчинд сөрөг нөлөөтэй эдийн засаг, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд өндөр татвар оногдуулж, байгальд ээлтэй сэргээгдэх эрчим хүчний эх сурвалжуудыг ашиглахыг зорьдог.
- **Нийгмийн хамгааллын бодлого:** Засгийн газар иргэдийнхээ зайлшгүй, суурь хэрэгцээнүүдэд баталгаа гаргах бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настай болон ажилгүй иргэдээ хамгаалах тусгайлсан бодлого баримталдаг.
- **Цагаачлалын асуудал:** Цагаачлалын асуудлаар төрийн зүгээс олон ургальч, аядуу бодлого явуулдаг.
- **Гадаад бодлого:** Ардчилал, хүний эрхийг хамгаалсан олон улсын үзэл санааг дэмжиж, олон талт гадаад бодлогыг хэрэгжүүлдэг.

Энвайронментализм: Байгалийн нөөц болон экосистемийг хамгаалах, хүрээлэн буй орчны чанарыг дээшлүүлэх зорилготойгоор үүссэн харьцангуй шинэ үзэл суртал хэдий ч 19-р зууны “Аж үйлдвэржилтийн хувьсгал”-ыг эсэргүүцэж анхны үзэл санаанууд нь гарч ирж байсан. Энвайронментализмын гол зорилго нь эдийн засгийн хөгжлийг нэмэгдүүлэх зорилготойгоор байгаль орчинд учруулсан хор хохирол/цөмийн технологи, хүчлийн бороо, озоны цоорол, дэлхийн дулаарал г.м/-ын нөлөөллийг бууруулж, хүн төрөлхтний амьдрах орчин, амьдралын чанарыг дээшлүүлэхийн төлөө оршдог. Үүнээс үүдэлтэйгээр хүн төрөлхтөн бол байгалийн нэг хэсэг гэх эгоцентрист үзлийг дэвшүүлэн гаргаж ирсэн.

Энвайронментализмын үзэл санаа нь

- Эрт дээр үеэс хүмүүс орчин үеийн ногоон хөдөлгөөнүүдийн хэрэгжүүлдэг үйл ажиллагаатай ижил төсөөтэй үйлдлүүдийг явуулж байсан.

- 19-р зууны эрдэмтэн Т.Мальтус¹⁰-ын дэвшүүлсэн хүн төрөлхтний өсөлт геометр прогрессээр явагдаж байхад хүнс тэжээлийн нийлүүлэлт арифметик прогрессээр өсч байна. Энэхүү зүй тогтол нь бүх нийтийг хамарсан өлсгөлөнгийн шалтгаан болно гэж үзсэн.
- Хүрээлэн буй орчны асуудал бол дэлхий үүссэн цагаас хойш байсан хэдий ч хүн төрөлхтөн “дэлхийн тэнцвэрийн систем¹¹”-ийн хөгжилд аюул учруулж байна.

Эдгээр үндэслэлүүдээс үүссэн.

Монгол дахь улс төрийн намууд

Я.Цэвэлийн Монгол хэлний тайлбар тольд “Нам гэдэг нь санаа зорилго нэгтэй бүлэг хэсэг; нийгмийн нэгэн ангийн жолоодох хэсэг нь бөгөөд түүнийг ашиг тусыг хамгаалж, нөгөө эсрэг ангитай явуулах тэмцлийн нь удирдах улс төрийн байгууллага” гэж тайлбарласан бөгөөд 1921 оны 03 дугаар сарын 01-ны өдөр Д.Сүхбаатар тэргүүтэй журмын нөхөд Монгол Ардын Намыг үүсгэн байгуулснаар анхны улс төрийн нам үүссэн гэж үздэг.

Улс төрийн намын тухай хуульд зааснаар:

“3.1 Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн сайн дурын үндсэн дээр нам байгуулах, намд элсэх, намаас гарах, хууль болон тухайн намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нийцүүлэн улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрхтэй.

4.1 Нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн” (хууль, 2015) гэж хуульчлан баталсан бөгөөд өнөөдрийн байдлаар Монгол Улсын Дээд шүүхэд бүртгэлтэй 24-н улс төрийн нам үйл ажиллагаа явуулж байна. Үүнд: /хавсралт I/

Эдгээр улс төрийн намуудаас идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй /сүүлийн 4 удаагийн сонгуульд оролцсон байдлыг үндэслэн/ намууд нь:

1. Монгол Ардын Нам /МАН/
2. Ардчилсан Нам /АН/
3. Монгол Ардын Хувьсгалт Нам /МАХН/
4. Бүгд Найрамдах Нам /БНН/
5. Иргэний Зориг Ногоон Нам /ИЗНН/
6. Монголын Үндэсний Ардчилсан Нам /МУАН/

Эдгээр улс төрийн намуудын үзэл баримтлал нь:

1. Монгол Ардын Нам: “Монгол Ардын Нам нь МАХН-ын зүй ёсны эхлэл ба үргэлжлэл бөгөөд Монгол Улсын тусгаар тогтнол, эрх чөлөө, шударга ёс, эв нэгдэл, үндэсний язгуур эрх ашгийг эрхэмлэн дээдэлсэн нийгмийн ардчиллын /социал-демократ/ үзэл баримтлал бүхий зүүн төвийн нам мөн.”
2. Ардчилсан нам: “Нийгмийн хөгжилд монголын ард түмнийг анхлан уриалан дуудсан улс төрийн хүчнүүдийн нэгдэл бол ардчилсан нам билээ. Монгол хүн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй болсон эрх чөлөөт-иргэдээс бүрдэх нийгмийн үндэс суурь бүрэлдсэн ардчилал, зах зээлд тулгуурласан хөгжил эргэлт буцалтгүй болсныг тэмдэглэн, Монгол улсад хүний эрх, эрх чөлөө биеллээ олох нөхцөлийг баталгаажуулах шаардлагатайг, Иргэний нийгмийн хөгжлийн сорилтыг давах чадвар төлөвшөөгүйг эрх чөлөөт иргэний нээлттэй нийгмийн хөгжлийг батжуулан төгөлдөржүүлэх үүрэг улам бүр нэмэгдэж буйг гүнээ ухамсарлан, Ардчиллыг бэхжүүлэн хөгжүүлэх намын хүсэл зориг, чадамж намын дотоод ардчиллаар хангагдана гэдгийг иш үндэс болгон тулгуур үзэл баримтлалаа үйл ажиллагааны удирдлага болгон хэрэгжүүлэхээр тодорхойлов”.
3. Монгол Ардын Хувьсгалт Нам: “Улс орныхоо тусгаар тогтнолыг бататган хамгаалах, үндэсний эрх ашгийг эрхэмлэн дээдлэх, ард түмнийхээ язгуур эрх ашгийг хүндэтгэн хангах нь МАХН-ын хамгаас эрхэмлэх үнэт зүйл мөн” хэмээн намын дүрэмдээ заасан бөгөөд үзэл баримтлалын тал дээр тусгайлан тодорхойлсон зүйл үгүй байна.
4. Бүгд Найрамдах Нам: “Нийгэмд хөдөлмөрийг дээдлэх, шүтэх явдлыг төлөвшүүлэх хүн, эдийн засаг байнга хөгжин дэвжиж байх эрх зүйн орчинг бүрдүүлж хэрэгжилтийг хангах, эрх мэдэл албан тушаалаа хувийн зорилгодоо ашигласан, нийгмийн баялгийг зүй бусаар хувиарласан/хуваарилсан, хүртсэн аливаа үйлдэлтэй хатуу тэмцэх, төрийн нэр хүндийг халдашгүй байлгаж дээшлүүлэх консерватив үзэл номлолыг улс төрийн үйл ажиллагааныхаа үндэс болгоно”

¹⁰ Thomas Malthus /1766-1834/

¹¹ Дэлхий өөрөө өөрийгөө нөхөн сэргээх үйл явц явуулдаг

5. Иргэний Зориг Ногоон Нам: Монголын Ардчилсан хувьсгалын хөдөлгөөны удирдагчдын нэг, нэрт улс төрч С.Зориг агсан бусдын гарт зэрлэгээр хөнөөгдсөний дараа түүний дүү С.Оюун болон ахтайгаа үзэл бодол, үйл хэрэг нэг улс төрчдийн хамтаар 2000 оны 03 дугаар сарын 09-ны өдөр ахынхаа үйл хэргийг үргэлжлүүлэх зорилгоор Иргэний Зориг Намыг үүсгэн байгуулсан. 2010 онд намын дүрэмдээ өөрчлөлт оруулж, намыг нэрийг Иргэний Зориг Ногоон Нам болгон шинэчилсэн бөгөөд “*Байгаль орчныг хамгаалсан чөлөөт зах зээлийн бодлогоор улсаа хөгжүүлэх үзэл баримтлалыг хэрэгжүүлдэг*” хэдий ч байнгын үйл ажиллагаа явуулахгүйгээр зөвхөн сонгуулийн жилүүдэд идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна.
6. Монголын Үндэсний Ардчилсан Нам: 2006 онд М.Энхсайхан тэргүүтэй улс төрчид Ардчилсан намаас гарч Үндэсний Шинэ Намыг байгуулсан бөгөөд 2011 оноос Намын дүрэмдээ өөрчлөлт оруулан намын нэрийг Монголын Үндэсний Ардчилсан Нам болгож Улсын Дээд шүүхэд бүртгүүлсэн байдаг. Либерал Ардчилсан үзэл суртлыг хэрэгжүүлэгч улс төрийн нам хэдий ч байгуулагдсан цагаасаа УИХ-ын сонгуулиудад улс төрийн бусад намуудтай эвсэн оролцсон бөгөөд улс төрийн хүчтэй лидерт тулгуурлан үйл ажиллагаа явуулж байна.

1990 оны ардчилсан хувьсгалын дараагаар Монголын нийгэм, эдийн засаг, улс төрд суурь шинжтэй олон өөрчлөлтүүд хийгдэж Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлаас “БНМАУ-ЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ”-ийг батлан хэрэгжүүлж улмаар Улс төрийн намуудын тухай хуулийг батласанаар 70 жил нэг намын тогтолцоотой байсан Монгол Улс олон намын тогтолцоотой болох эрх зүйн орчин бий болж, эв санаагаараа эвлэлдэн нэгдсэн иргэдийн улс төрийн нам байгуулах үйл явц хурдацтайгаар явагдаж, дээр өгүүлсэн¹² улс төрийн намууд төрөн гарсан.

Өнгөрсөн долоон удаагийн УИХ-ын сонгуулийн үйл явцыг бүхэлд нь харахад МАН, АН-аас бусад улс төрийн намууд зөвхөн сонгуулийн үеэр үйл ажиллагаагаа идэвхижүүлж, бусад намуудтай эвсэж, нэгдэж парламентын сонгуульд оролцон, төлөөлөлтэй болох, том намуудыг дэмжиж ажиллах зэрэг үйл ажиллагаа явуулж буй тохиолдлууд олон байна. Улсын дээд шүүхэд бүртгэлтэй эдгээр 24 намаас улс төрийн намын үзэл суртлынхаа хүрээнд тогтвортой үйл ажиллагаа явуулж буй нам бараг байхгүй гэж хэлэхэд болохоор төдийгүй өөрийн байргүй, дүрмийн дагуу Их хурал, Бага хурал, Удирдах зөвлөлийн хурлууд нь явагдалгүйгээр олон жилийг өнгөрөөсөн, зөвхөн цаасан дээр л байх “Нэг” хүний намууд олон байна.

Улс төрийн нам, үзэл суртлаа тууштай хэрэгжүүлэх нь гишүүд дэмжигчид болон олон түмний итгэлийг хүлээж, сонгуульд ялалт байгуулах тулгуур хүчин зүйл болдог. Тогтсон үзэл суртлын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй улс төрийн нам, нийгэмд эзлэх байр сууриа батжуулах, гишүүд дэмжигчдээ улам бүр нэмэгдүүлэн хүрээгээ тэлэх, иргэдийн итгэлийг хүлээх зөв имижийг бүрдүүлэх зэрэг олон эерэг талуудтай байдаг. Мөн сөрөг хүчний байр сууринаас эрх барьж буй намын үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандах, үзэл суртлынхаа ялгаатай байдлаар улс төр хийх явдал нь төлөвшсөн үзэл баримтлалтай улс төрийн намын гол үйл ажиллагаа юм.

Харин манай улсын дийлэнхи намууд үзэл суртал, чиг баримжаа байхгүйгээр үл барам, улс төрийн намын үндсэн зорилго болох засгийн эрхийг сонгуулийн дагуу авах бус анх байгуулагдсан цагаасаа эхлэн нэг хүний юмуу бүлгийн эрх ашгийг илэрхийлэх, тодорхой зорилгыг л хэрэгжүүлхийн төлөө эвлэлдэн нэгдэж, түүндээ хүрхээр эрчимжин ажиллах, дараа нь идэвхигүй болох, сонгуулийн үеэр ашиг хонжоо олох зэрэг үйл ажиллагаануудыг өргөнөөр явуулсаар байна. Улс төрийн намын энэхүү төлөвшөөгүй байдал нь Монголын улс төрийн амьдралд нэн хортой нөлөө үзүүлж байгаа бөгөөд одоо үйлчилж буй улс төрийн намуудын тухай хууль болон бусад эрх зүйн баримт бичгүүдээр эдгээр асуудлыг өөрчилж чадахгүй явсаар л байна. Улс төрийн намуудад хяналт тавих байгууллага нь Монгол Улсын Дээд Шүүх хэдий ч улс төрийн намуудыг бүртгэхээс өөр хяналтгүй байгаа бөгөөд үйл ажиллагаа явуулж буй Дээд Шүүхэд бүртгэлтэй нам өөрийн хаяг дээрээ байрладаггүй, орон байргүй, хаяг байршил, утас тодорхойгүй зэрэг асуудалтай олон зүйлс байна. Улс төрийн намууд өөрсдийн дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулахад нь хяналт тавих, үзэл суртал, чиг баримжааныхаа хүрээнд шат шатны сонгуульд оролцож байгаад нь анхаарах, олон жил үйл ажиллагаа явуулаагүй нам, эвслийн бүртгэлийг гаргаж, шаардлагатай тохиолдолд хаах хүртэл арга хэмжээ авах нь өнөөгийн Монголын улс төрийн хүрээнд зайлшгүй хийх шаардлагатай тулгамдсан асуудал болоод байна.

Abstract: A political ideology is a coherent set of views on politics and the role of political party. It's significant to understand ideology of political party and how it forms. Therefore we analysis ideologies of political parties of Mongolia and compared its ideological structure.

¹² Хавсралт 1

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД БҮРТГЭЛТЭЙ
УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ЖАГСААЛТ**

Д/д	Намын нэр	Намын дарга	Хаяг, утас, факс, цахимхуудас	Анх байгуулагдсан огноо	Улсын Дээд шүүхэд бүртгүүлсэн огноо	Гишүүдийн тоо
1	Монгол Ардын Нам /МАН/	М.Энхболд	Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Тусгаар тогтнолын ордон 77444158, ф-77444158 contact@mpp.mn	1921.03.01	1990 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор бүртгүүлсэн.	161300
2	Ардчилсан Нам /АН/	З.Энхболд	Сүхбаатар дүүрэг, Ардчилсан намын төв байр 262055, 264221, 262862 info@demparty.mn	2000.12.06 МҮАН, МСДН, МШАН, МАСМН, МоАН-ууд нийлсэн, МСДН-ийн улсын бүртгэлийн дугаарт бүртгэсэн.	УДШ-ийн 2000.12.26-ны өдрийн 7 дугаар тогтоолоор "Ардчилсан нам"-ын хүсэлтээр улсын бүртгэлийн дугаарт бүртгэхдээ МСДН-ыг улсын бүртгэлд анх бүртгүүлсэн дугаараар тооцсон байна. /1990.05.25/	150000
3	Монголын Ногоон Нам /МНН/	О.Бум-Ялагч	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо Элеганс төв 70110680, 99902979,99114162 info@nogoonton.com	1990.05.13	1990 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 06 дугаар тогтоолоор бүртгүүлсэн.	2100
4	Иргэний Зориг Ногоон Нам /ИЗНН/	С.Оюун, Д.Энхбат, С.Дэмбэрэл	Сүхбаатар дүүрэг, Интерном "Б" корпус 319006, 314560, 99114264 zorigsan@hotmail.mn info@civilgreen.mn	УДШ-ийн 2002 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор Иргэний Зориг-Бүгд Найрамдах намыг бүртгэхдээ улсын бүртгэлд анх бүртгүүлсэн дугаараар 1992.04.07-ны өдрөөр тооцсон байна.	Иргэний Зориг, Бүгд Найрамдах намууд нийлсэн, БНН-ын улсын бүртгэлийн дугаарт бүртгүүлсэн. Тус намын нэрийг Улсын дээд шүүхийн иргэний хэргийн шүүх хуралдааны 2006.3.23-ны өдрийн 02 дугаар тогтоолоор "Иргэний Зориг Нам" болгон өөрчлөв. 2012 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 02 дугаар тогтоолоор "Иргэний Зориг Ногоон Нам" болгон бүртгүүлсэн.	35000
5	Монголын Уламжлалын Нэгдсэн нам /МУНН/	Б.Багболд	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо "Мика" зочид буудал 99710095, 99191673, 99114567 munn@madicnet.mn	1993.12.05 ММТНН, МХӨНН, МТТ намууд нийлсэн.	1994 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор бүртгүүлсэн.	1503
6	Монголын Либерал Ардчилсан Нам /МЛАН/	Т.Төмөрмөнх	Сүхбаатар дүүрэг, түрээсийн байр 319747, 323686, 323860	1998.03.05	1998 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор бүртгүүлсэн.	863
7	Эх Орон Нам /ЭОН/	Б.Эрдэнэбат	Улаанбаатар-47, Жуковын өргөн чөлөө-7а, Эх Орон намын төв байр 453178, 90150268	УДШ-ийн 1998.12.22-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор Монголын Ардчилсан Шинэ социалист нам улсын бүртгэлд бүртгүүлсэн болно.	2000 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 06 дугаар тогтоолоор Монголын Ардчилсан Шинэ социалист намын нэрийг "Эх-Орон-Монголын Ардчилсан Шинэ социалист нам" гэж өөрчилснийг бүртгэсэн. 2005.01.20-ний өдрийн 02 дугаар тогтоолоор "Эх орон" нам гэж өөрчилснийг бүртгэсэн.	160000
8	Монголын Либерал нам /МЛН/	Намын даргын үүрэг гүйцэтгэгч Б.Амгаланбаатар	Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар эрдэм оюу дээд сургуулийн байр 328198, 99072799 Liberal.mn	1999.12.17	2000 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор бүртгүүлсэн.	1300

9	Бүтэ Найрамдах Нам /БНН/	Б.Жаргалсайхан	Баянгол дүүрэг, 3 дугаар хороо, Буян-Холдинг ХХК-ний байр 99130905, 91917443, 99857099	2004.03.15	2004 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоолоор бүртгүүлсэн.	50000
10	Монголын Эмэгтэйчүүдийн Үндэсний Нэгдсэн Нам /МЭҮНН/	Г.Тунгалагэрэл	Сүхбаатар дүүрэг, "Шувуун саарал" УУГ-ын "Б" корпус 324877	2003.12.16	2004 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 03 дугаар тогтоолоор бүртгүүлсэн.	1069
11	Монголын Социал Демократ Нам /МСДН/	А.Ганбаатар	Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо 5 дугаар байр 12 тоот 99114273, 91177272 secretariat@msdp.mn	2004.12.19	2005 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор бүртгүүлсэн.	3000
12	Ард Түмний Нам /АТН/	Намын даргын үүрэг гүйцэтгэгч Н.Наранцогт	Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо "Баг-Сарай" ХХК-ний Лаки төвийн байр 99114140, 91144343, 99681212 info@ardtumen.mn	2005.12.11	2005 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 12 дугаар тогтоолоор бүртгүүлсэн.	11859
13	Монгол Үндэсний Ардчилсан Нам /МУАН/	М.Энхсайхан	Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 24/3 99116001, 99118888, 91929022 info@muan.mn	2006.05.19	2006 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор бүртгүүлсэн.	26000
14	Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Нам /ЭЧХН/	Ш.Төмөрсүх	Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо Зохиолчдын эвлэлийн хорооны байр 70112256, 99113439	2006.10.09	2007 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор бүртгүүлсэн.	1600
15	Иргэний Хөдөлгөөн Нам /ИХН/	Б.Багсайхан	Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-49 Мэдээллийн технологийн үндэсний парк 321900, 99111403, info@ihnam.mn	2007.08.17	2007 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор бүртгүүлсэн.	815
16	Хөгжлийн Хөтөлбөр Нам /ХХН/	Н.Зууннаст	Сүхбаатар дүүрэг, 14 дүгээр хороо "Ядууралтай тэмцэх Хөгжлийн хөтөлбөр сан"-гийн байр 96019222	2007.10.28	2007 оны 10 дугаар сарын 30-ний өдрийн 05 дугаар тогтоолоор бүртгүүлсэн.	933
17	Монголын Ардчилсан Хөдөлгөөний Нам	Т.Оюунаа	Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо Их сургуулийн гудамж 3/2 99009093, 91999901, 210620	2008.02.01	2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор бүртгүүлсэн.	850
18	Монгол Ардын Хувьсгалт Нам /МАХН/	Н.Энхбаяр	Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо Олимпийн гудамж 5 дугаар байр 99109619, 99078778	2011.01.28	2011 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 07 дугаар тогтоолоор бүртгүүлсэн.	35000
19	Хамуг Монгол Хөдөлмөрийн нам /ХМХН/	С.Молор-Эрдэнэ	Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо "Монгол хэвлэл" ХХК-ний байр	2011.09.23	2011 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 13 дугаар тогтоолоор бүртгүүлсэн.	2000
20	Хөдөлмөрийн Үндэсний Нам /ХҮН/	С.Боргил	Чингэлтэй дүүрэг, 2 дугаар хороо Энхтайвны өргөн чөлөө 4 дүгээр байр 91911466, 99098268 contact@hun.mn	2011.11.05	2011 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор бүртгүүлсэн.	1024
21	Эх Орончдын Нэгдсэн Нам /ЭОНН/	Г.Ганбат	Баянгол дүүрэг, 8 дугаар хороо 11 дүгээр байр 260 тоот 99113622, 88866402, 96671779	2012.06.20	2012 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор бүртгүүлсэн.	2150

22	Монгол Консерватив Нам / МКН/	Н.Данцлаваа	Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо Peace Building төв 99109310, 99112826, 91910889	2012.06.20	2012 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор бүртгүүлсэн.	959
23	Тусгаар тогтнол, эв нэгдлийн нам / ТТЭНН/	Ц.Баянбилэг	Баянгол дүүрэг, 8 дугаар хороо “Алтан онгоц” ХХК- ний байр 88808574, 99628944	2015.04.18	2015 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 07 дугаар тогтоолоор бүртгүүлсэн.	3131
24	Ард түмнээ хайрлая нам / АТХН/	Л.Гүндалай	Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо Зайсан гэйт зочид буудлын байр 99114140, 313725	2015.04.20	2015 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор бүртгүүлсэн.	1388

НОМ ЗҮЙ:

1. Eatwell, R., & Wright, A. (1993). *Contemporary Political Ideologies*. Colorado: Westview Press, Inc.
2. Heywood, A. (2002). *Politics*. New-York: Palgrave MacMillan.
3. Institute, N. D. (2008). *Manual on Political Party Identity and Ideology*. Washington DC: National Democratic institute.
4. Wilhelm Hofmeister, K. G. (2011). *Political Parties; Functions and Organization in Democratic Societies*. Berlin: Konrad Adenauer Stiftung.
5. Батжаргал, Г. (2006). *Нийгэм, улс төрийн сэтгэлгээний онолын асуудлууд*. Улаанбаатар: “Шинэ Өнгө” ХХК.
6. Баут, С. (2009). *Эдийн Засаг ба Нийгмийн Ардчилал*. Бони: Фридрихх Эбэртийн Сан.
7. Вольф, Ж. (2002). *Улс төрийн философийн удиртгал*. Улаанбаатар: .
8. мэдээлэл, У. т. (n.d.). *news.mn*. Retrieved from <http://www.news.mn/r/233951>
9. Т.Сэнгэдорж. (1998). *Монгол улсын төр эрх зүйн үндэс*. Улаанбаатар: Монгол Улсын Их Сургууль.
10. Хороо, М. У. (2016). Retrieved from <http://www.supremecourt.mn/nam>
11. Хууль, М. У. (2015). *Сонгуулийн тухай*. Улаанбаатар.
12. хууль, У. т. (2015). *Улс төрийн намын тухай хууль*. Улаанбаатар